



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/242

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Чигжийн голын гүүр барих /Бүрэнтогтох сум/ дуусгалтын ажил ХӨАХААГ/20240101100 дугаартай тендерт 57,849,516 (Тавин долоон сая найман зуун дөчин есөн мянга таван зуун арван зургаа) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Гоо жим” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Гоо жим” ХХК-ийн гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа) томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

М.Сарангэрэл

Б.Цэнддэлгэр

(“Уран дөш” ОНӨААТҮГ -ын захирал)
(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан
ахлах мэргэжилтэн)

Б.Нямбаяр

(“Гоо Жим” ХХК-ийн инженер)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Н.Буян-Өлзий

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө
оруулалтын хэлтсийн Авто замын
хяналтын улсын байцаагч)

3. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Чигжийн голын гүүр барих /Бүрэнтогтох сум/ дуусгалтын ажлын ХӨАХААГ/20240101100 гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын

d/A4

871010730

гүйцэтгэлийн үе шатанд хийх захиалагчийн хяналтыг "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, уг гэрээг дүгнэх, ил далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хүргүүлэх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан, барилга байгууламжийн гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, гэрлэн дохиог ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон тус газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ